



БАЯНХОНГОР АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ХУРЛЫН ТОГТООЛ

2019 оны 04 сарын 26 өдөр

Дугаар 57

Номгон

Цэргийн албыг дүйцүүлэн хаах
иргэдийн тоо батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 03 дугаар сарын 27-ны өдрийн 80 дугаар тогтоолоор батлагдсан “Цэргийн албыг дүйцүүлэн хаах журам”, Засгийн газрын 2018 оны 08 дугаар сарын 15-ны өдрийн “Цэргийн дүйцүүлэх алба хаах иргэдийн тооны дээд хязгаарыг тогтоох тухай” 249 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Цэргийн албыг 2019-2021 онд сумдад цэргийн албыг дүйцүүлэн хаах иргэдийн тоог хавсралтаар баталсугай.

2. “Цэргийн албыг дүйцүүлэн хаах журам”-ыг удирдлага болгон дүйцүүлэх албыг хаалгах ажлыг зохион байгуулахыг Баацагаан, Баянбулаг, Баянговь, Баянлиг, Баян-Овоо, Баян-Өндөр, Баянхонгор, Баянцагаан, Бөмбөгөр, Бууцагаан, Галуут, Гурванбулаг, Жаргалант, Заг, Өлзийт, Хүрээмарал, Шинэжинст, Эрдэнэцогт сумдын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын дарга нарт зөвлөж, Засаг дарга нарт үүрэг болгосугай.

3. Цэргийн албыг дүйцүүлэн хаах иргэдийг зохих журмын дагуу алба хаалгахад хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штаб /хурандаа Б.Энхбаатар/-т даалгасугай.

ДАРГА



Ц.ОТГОНБАЯР

1190041

D:/2018/Alban bichig/th togtool-2019

Аймгийн Иргэдийн төлөөлөгчийн хурлын
2019 оны 04 дүгээр сарын 26-ны өдрийн
57 дугаар тогтоолын хавсралт

ЦЭРГИЙН АЛБЫГ 2019-2021 ОНД БИЕЭР
ДҮЙЦҮҮЛЭН ХААХ ИРГЭДИЙН ТОО

д/д	Сумдын нэр	Алба хаах иргэдийн
1.	Баацагаан	2
2.	Баянговь	2
3.	Баянлиг	3
4.	Баян-Овоо	2
5.	Баян-Өндөр	2
6.	Баянхонгор	3
7.	Баянцагаан	1
8.	Бөмбөгөр	1
9.	Бууцагаан	2
10.	Галуут	3
11.	Гурванбулаг	1
12.	Баянбулаг	2
13.	Жаргалант	1
14.	Заг	2
15.	Өлзийт	5
16.	Эрдэнэцогт	4
17.	Хүрээмарал	3
18.	Богд	1
	Нийт	40

_____оОо_____